# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 5 (386)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Зарим хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн үлгэрчилсэн дүрмийг батлах тухай*
- *Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтцийг батлах тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**
**Улаанбаатар хот**
**2005 он**

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот 2005 оны хоёрдугаар сарын 7 №5 (386)


## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


521. Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 95

522. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай 96

523. Гаалийн тарифын тухай хуульд нэмэлт оруулах тухай 96

524. Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 97

525. Аялал жуулчлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 97

526. Авто тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай 98

527. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 98

528. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 99

529. Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 100

530. Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 101

531. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 101

532. Зохиогчийн эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 101

533. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 101

534. Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 102

535. Засаг захиргааны, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 102

536. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 102

537. Патентийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 103

538. Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 103

539. Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 103

540. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 103

541. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 104
542. Орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 104
543. Усны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 104
544. Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай 104
545. Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 105
546. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 105
547. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 105
548. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 106
549. Шуудангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 106
550. Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 106
551. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 106
552. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 107

## Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

553. Хэлэлцээр батлах тухай Дугаар 1 107
554. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн үлгэрчилсэн журмыг батлах тухай Дугаар 2 107
555. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтцийг батлах тухай Дугаар 3 109
556. Тогтоолын хавсралт хүчингүй болгох тухай Дугаар 4 110
557. Хэлэлцээр батлах тухай Дугаар 5 110
558. Төлбөрийн хувь хэмжээг тогтоох тухай Дугаар 7 110
559. Гадаадаас 2005 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай Дугаар 9 111

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 2005 он №5 (386)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, зүйл тус тус нэмсүгэй:

**1/ 20 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэг:**

"6.Шадар сайдын түр эзгүйд түүний үүргийг Шадар сайдын саналыг үндэслэн Ерөнхий сайдын үүрэг болгосон Засгийн газрын аль нэг гишүүн гүйцэтгэх бөгөөд ийнхүү Шадар сайдын үүргийг гүйцэтгэж байгаа Засгийн газрын гишүүн Ерөнхий сайдаас олгосон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, хариуцлага хүлээнэ.

7.Энэ хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 16, 17-д заасан Засгийн газрын гишүүн түр эзгүй байх тохиолдолд Ерөнхий сайдын үүрэг болгосон Засгийн газрын аль нэг гишүүн түүний үүргийг гүйцэтгэх бөгөөд ийнхүү үүрэг гүйцэтгэж байгаа Засгийн газрын гишүүн Ерөнхий сайдаас олгосон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, хариуцлага хүлээнэ."

**2/ 24 дүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэг:**

"5.Засгийн газрын гишүүн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн олонхийн саналаар шийдвэрлэсэн хуулийн төсөл, төрийн бодлогын зарчмын бусад асуудлаар Улсын Их Хурлын чуулган, Байнгын хорооны хуралдаанд Засгийн газрын гишүүний хувьд зарчмын өөр санал илэрхийлэхгүй.

6.Засгийн газрын гишүүн хууль тогтоомжоор эрх олгоогүй, түүнчлэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээгүй буюу хэлэлцсэн боловч олонхийн дэмжлэг аваагүй асуудлаар Засгийн газрыг төлөөлөх эрхгүй."

**3/ $34^1$ дүгээр зүйл:**

**"$34^1$ дүгээр зүйл. Шадар сайдын ажлын алба**

1.Шадар сайд ажлын албатай байна. Ажлын албаны ажилтан ажлаа Шадар сайдын өмнө хариуцаж, Хэрэг эрхлэх газарт харьяалагдана.

2.Шадар сайдын ажлын албаны орон тооны хязгаар, зардлын төсвийг Засгийн газар тогтооно."

**2 дугаар зүйл.** Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "түүний дотор" гэсний дараа "Шадар сайд болон" гэж, 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтын "Хэрэв" гэсний дараа "Шадар сайд эсхүл" гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Засгийн газрын тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/ 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

"2.Ерөнхий сайдын түр эзгүйд түүний үүргийг Монгол Улсын Шадар сайд гүйцэтгэнэ. Ерөнхий сайд, Шадар сайд нэгэн зэрэг түр эзгүй байх тохиолдолд Ерөнхий сайдын үүрэг болгосноор Засгийн газрын аль нэг гишүүн Ерөнхий сайдын үүргийг гүйцэтгэнэ. Ерөнхий сайдын үүргийг гүйцэтгэж байгаа Засгийн газрын гишүүн Ерөнхий сайдаас олгосон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, хариуцлага хүлээнэ."

**2/ 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэр:**

"Дэд сайдыг асуудал хариуцсан сайдын саналыг үндэслэн Ерөнхий сайд Шадар сайдтай зөвшилцөн санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө."

**3/ $18^1$ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:**

"2/ сайдаас олгосон бүрэн эрхийн хүрээнд харьяа агентлаг, байгууллагатай ажилтай харилцах, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;"

**4/ $18^2$ дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

"4.Хэрэг эрхлэх газрын дарга Ерөнхий сайдын өмнө ажлаа хариуцаж, Шадар сайдад ажлаа танилцуулна."

**5/ 21 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг:**

"3.Ерөнхий сайдын бүрэн эрх биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болж, үүргээс чөлөөлөгдсөн, нас нөхчсөн, үндсэн хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд Ерөнхий сайдыг шинээр томилох хүртэл түүний үүргийг Шадар сайд гүйцэтгэнэ.

4.Засгийн газрын орон гарсан гишүүнийг нөхөн томилох хүртэл Ерөнхий сайд Шадар сайдтай тохиролцон Засгийн газрын нэг буюу хэдэн

гишүүнд түүний үүргийг хуваарилан хариуцуулж болно."

**6/ 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх өгүүлбэр:**

"2.Засгийн газар асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол шийдвэр гараагүйд тооцно.".

**4 дүгээр зүйл.** Засгийн газрын тухай хуулийн $18^1$ дүгээр зүйлийн 10 дахь хэсгийн "Ерөнхий сайдад" гэснийг "Ерөнхий сайд болон Шадар сайдад" гэж, $18^3$ дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Ерөнхий сайд" гэснийг "Засгийн газар" гэж, 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх заалтын "бүс нутгийн хөгжлийн бодлого" гэснийг "бүс нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого" гэж, мөн заалтын "хүүхэд, залуучуудын асуудал" гэснийг "хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал" гэж, 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "бодлогыг тодорхойлно" гэснийг "үйл ажиллагааг удирдана" гэж, мөн хэсгийн 5 дахь заалтын 3 дахь өгүүлбэрийн "4 дэх" гэснийг "5 дахь" гэж, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "$18^2$" гэснийг "$18^3$" гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн 1, 2 дахь өгүүлбэрийн "Ерөнхий сайдын бодлогыг" гэснийг "Засгийн газрын бодлогыг" гэж, мөн хэсгийн 2 дахь өгүүлбэрийн "Ерөнхий сайдад" гэснийг "Засгийн газарт" гэж, мөн зүйлийн 5-8 дахь хэсгийн дугаарыг "7-10" гэж, 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтын "дангаар" гэснийг "Шадар сайдтай санал нэгдэж" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалтын "Ерөнхий сайдад" гэснийг "Ерөнхий сайд болон Шадар сайдад" гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх өгүүлбэрийн "Ерөнхий сайд шууд буюу шаардлагатай бол" гэснийг хассугай.

**6 дугаар зүйл.** Засгийн газрын тухай хуулийн $18^1$ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДЭД**
**ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр** **Улаанбаатар хот**

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9.2-т дараахь заалт нэмсүгэй;

"9.2.17. импортоор орж ирж байгаа бөөрөнхий мод, гуалин, зүсмэл материал, хориглосноос бусад мод, сөөгний үр, тарьц, суулгац."

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДЭД**
**ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр** **Улаанбаатар хот**

### ГААЛИЙН ТАРИФЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гаалийн тарифын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дараахь заалт нэмсүгэй:

"15/ импортоор орж ирж байгаа бөөрөнхий мод, гуалин, зүсмэл материал, хориглосноос бусад мод, сөөгний үр, тарьц, суулгац."

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДЭД**
**ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Авто замын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн гарчиг болон 14.2-ын "өмчлөгч" гэсний өмнө "эзэмшигч," гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Авто замын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"14.1.Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжийн эзэмшигч нь /цаашид "авто замын эзэмшигч" гэх/ авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн эзэмшигч нь аймаг, нийслэлийн Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын авто замын өмчлөгч, эзэмшигч нь тухайн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн байна."

**3 дугаар зүйл.** Авто замын тухай хуулийн 18.1-ийн "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн" гэснийг "төрийн захиргааны төв байгууллагын" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Аялал жуулчлалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 16.1.8- 16.1.14 дэх заалт нэмсүгэй:

"16.1.8. Монгол орныг гадаад, дотоодод сурталчлах;

16.1.9. дээд зэрэглэлийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох;

16.1.10. аялал жуулчлалын статистик мэдээллийг нэгтгэж, судалгаа, дүн шинжилгээ хийх;

16.1.11. аялал жуулчлалын мэдээллийн нэгдсэн сүлжээ, сан байгуулах;

16.1.12. аялал жуулчлалын бүсэд хүлээн авах жуулчдын тоог тогтоох;

16.1.13. аялал жуулчлалын зам чиглэлийг тогтоох;

16.1.14. аялал жуулчлалын хөгжилд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулахыг хориглох."

**2 дугаар зүйл.** Аялал жуулчлалын тухай хуулийн 5.1, 8.1.3, 12.2, 22.2, 23.1.3, 23.1.7-ын "төрийн захиргааны" гэсний дараа "төв" гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Аялал жуулчлалын тухай хуулийн 15.3-ын "дэд бүтэц" гэснийг "аялал жуулчлал" гэж, 15.5-ын "төрийн захиргааны байгууллагын дарга" гэснийг "Засгийн газрын гишүүн" гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Аялал жуулчлалын тухай хуулийн 15.1, 22.2-ын "аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэснийг тус тус хассугай.

**5 дугаар зүйл.** Аялал жуулчлалын тухай хуулийн 14.1.6 дахь заалт, 17 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

## АВТО ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Авто тээврийн тухай хуулийн 8.2, 8.3, 15.3-ын "төв" гэсний өмнө "төрийн захиргааны" гэж тус тус нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД
ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

## АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.13, 15.14, 15.15, 15.16, 15.17 дахь хэсэг тус тус нэмсүгэй:

"15.13.Зохиогчийн эрх, патентийн чиглэлээр:

15.13.1.зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах;

15.13.2. патентийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах.

15.14. Барилга, хот байгуулалтын чиглэлээр:

15.14.1. нууцын зэрэглэлтэй байр зүйн зураг, тоон мэдээллийг хэвлэх;
15.14.2. кадастрын зураглал хийх;
15.14.3. цахилгаан шат, өргөх краны угсралт, засвар үйлчилгээ эрхлэх;

15.14.4. зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт засвар, үйлчилгээ эрхлэх;

15.14.5. нийтийн аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;

15.14.6. барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх;

15.14.7. геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;

15.14.8. газрын кадастрын судалгаа хийх.

15.15. Зам, тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр:

15.15.1.төмөр замын шугам барих;
15.15.2.иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх;

15.15.3. төмөр замын тээврийн үйлчилгээ эрхлэх;

15.15.4. автозам, замын байгууламжийг барих, засварлах ;

15.15.5. автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх;

15.15.6. улс хоорондын болон хот хоорондын нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх;

15.15.7. иргэний агаарын хөлгийг бүтээх, түүнд өөрчлөлт сайжруулалт хийх;

15.15.8. дээд зэрэглэлийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх;

15.15.9. усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх;

15.15.10.усан замын дохио, тэмдгийн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх.

15.16. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр:

15.16.1. радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах;

15.16.2.харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх.

15.17.Стандарчлал, хэмжил зүйн чиглэлээр:

15.17.1.хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах."

**2 дугаар зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.8-ыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"15.8. Түлш, эрчим хүчний чиглэлээр:

15.8.1.цөмийн эрчим хүчний нөөцөөр ажиллах эх үүсвэр барьж байгуулах, ажиллуулах;

15.8.2. эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах;

15.8.3. эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, диспетчерийн зохицуулалт хийх, түгээх, хангах, борлуулах үйл ажиллагаа эрхлэх;

15.8.4. шингэрүүлсэн шатдаг хийн үйлчилгээ эрхлэх."

**3 дугаар зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.5.9, 15.5.10, 15.6.4, 15.10.7, 15.10.8-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДЭД**
**ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр** **Улаанбаатар хот**

### ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Газрын тухай хуулийн 8.2, 8.4, 24.2, 26.6, 36.1, 42.1, 42.2, 48.1, 55.4, 57.1, 58.6-ын "төрийн захиргааны" гэсний дараа "төв" гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Газрын тухай хуулийн 19 дүгээр зүйл, 23.2.14, 23.2.17, 58.3-ыг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

**1/19 дүгээр зүйл:**

**"19 дүгээр зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

19.1. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.1.1.газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

19.1.2. газрын нэгдмэл сангийн тайланг Засгийн газарт танилцуулах;

19.1.3.газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн байгууллагын эрх олгох, цуцлах, тэдгээрийн ажиллах журам, зааврыг батлан мөрдүүлэх;

19.1.4.газар зохион байгуулалт, газрыг хамгаалах, нөхөн сэргээхэд зориулсан хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;

19.1.5.газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлалыг батлах;

19.1.6.энэ хуулийн 16.1.2- 16.1.9-д заасан газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ заагийг тогтоох саналаа Засгийн газарт оруулах;

19.1.7.улсын хэмжээнд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үйл ажиллагаанд хяналт тавих;

19.1.8.аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд дүгнэлт өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;

19.1.9.улсын хэмжээнд газрын кадастрын бодлого боловсруулах, үйл ажиллагааг удирдах;

19.1.10.газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах газрыг тогтоох болон нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх асуудлыг Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх;

19.1.11. газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүрмийг батлах.

19.2. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.2.1 энэ хуулийн 16.1.1-д заасан газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах,

үүний хэмжээ, заагийг тогтоох саналаа Засгийн газарт өргөх;

19.2.2. газрын элэгдэл, эвдрэлийн эрэглэ, цөлжилтийн төрөл, ангиллыг тогтоох, эдгээрийг тэмцэх, нөхөн сэргээх аргачлал, заавар, журмыг боловсруулж мөрдүүлэх."

/ 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 14 дэх заалт:

23.2.14.улсын хэмжээнд газрын кадастрын ходлогыг эрхлэх, улсын газрын мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх;"

/ 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 17 дахь заалт:

23.2.17.газар зохион байгуулалт, газрын кадастрын эрхлэх мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, дүгнэлт өгөх;"

/ 58 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

58.3.Энэ хуулийн 58.2-т заасан үзүүлэлт дээр тухайн газрын онцлогийг харгалзан нэмж хэрэглэх үзүүлэлт, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны үзүүлэлтийг тодорхойлох аргачлалыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно."

**3 дугаар зүйл.** Газрын тухай хуулийн 21.2.1-ийн "Засгийн газрын эрх бүхий байгууллагын" гэснийг "газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын" гэж, 23.2.1-ийн "төрөөс" гэснийг "Засгийн газраас" гэж, 23.2.5-ын "Засгийн газарт" гэснийг "газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад " гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Газрын тухай хуулийн 23.2.2, 23.2.9, 23.2.18- 23.2.20, 23.5-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2005 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр** **Улаанбаатар хот**

### ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.4 дэх хэсэг нэмсүгэй:

5.4.Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.4.1.геодези, зураг зүйн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

5.4.2.геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих;

5.4.3.Монгол Улсын нутаг дэвсгэрийг зурагжуулах төрийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх;

5.4.4.геодези, зураг зүйн заавар, журам батлах, стандартыг боловсруулж мөрдүүлэх;

5.4.5.олон улсын гэрээгээр геодези, зураг зүйн асуудлаар Монгол Улсын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

5.4.6.иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох."

**2 дугаар зүйл.** Геодези, зураг зүйн тухай хуулийн 5.6.2, 5.6.3, 7.2, 12.1.1-ийн "төрийн захиргааны" гэсний дараа "төв" гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Геодези, зураг зүйн тухай хуулийн 5.4 – 5.7 дахь хэсгийн дугаарыг "5.5 – 5.8" гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Геодези, зураг зүйн тухай хуулийн 5.4.1-ийн "Монгол Улсын нутаг дэвсгэрийг зурагжуулах төрийн нэгдсэн бодлого," гэснийг хассугай.

**5 дугаар зүйл.** Геодези, зураг зүйн тухай хуулийн 5.4.3, 5.4.4, 5.4.6-г тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр** **Улаанбаатар хот**

### ГЭРЭЭТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 10.2-ын "гэгээрлийн" гэснийг "боловсролын" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр** **Улаанбаатар хот**

### ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "дэд бүтцийн" гэснийг "автотээврийн" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр** **Улаанбаатар хот**

### ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Зохиогчийн эрхийн тухай хуулийн $6^1$ дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "төрийн захиргааны төв байгууллага" гэснийг "Засгийн газрын гишүүн" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Зохиогчийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд" гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр** **Улаанбаатар хот**

### МАЛЫН УДМЫН САН, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 4.3.8, 4.3.9, 4.3.10 дахь заалт нэмсүгэй:

"4.3.8.малын генийн болон ийлдсийн сан, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалахтай холбогдол бүхий мэдээллийн тогтолцоо бий болгож ажиллуулах;

4.3.9. малын өвчинтэй тэмцэх, сэргийлэх болон үржлийн ажлын талаар жил бүр авах арга хэмжээний эдийн засгийн тооцоо, эрсдэлийн үнэлгээ хийх;

4.3.10. гадаад улсын мэргэжлийн алба, байгууллагатай мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний чиглэлээр хамтран ажиллах гэрээ, хэлцэл хийх."

**2 дугаар зүйл.** Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4.3.2-ын "бодлогын" гэсний дараа "болон мэргэжил, арга

зүйн" гэж, 5.1, 11.2, 15.1.7-ын "төрийн захиргааны" гэсний дараа "төв" гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 5.2-ыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"5.2. Аймаг, нийслэлийн мал эмнэлэг, үржлийн албыг мал эмнэлэг, үржлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр аймаг, нийслэлийн Засаг дарга байгуулна."

**4 дүгээр зүйл.** Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 6.2-ыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр** **Улаанбаатар хот**

### МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ЦЭРГИЙН ҮҮРГИЙН БОЛОН ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийн "Иргэний хамгаалалтын мэргэжлийн анги, Байгалийн гамшигтай тэмцэх салбар" гэснийг "онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын аврах анги, отряд, салбар" гэж, мөн хэсгийн 4 дэх өгүүлбэрийн "Иргэний хамгаалалтын" гэснийг "Гамшгаас хамгаалах ажиллагааны" гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр** **Улаанбаатар хот**

### ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Монгол Улсын Засаг захиргааны сайд" гэснийг "Засаг даргын үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн " гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр** **Улаанбаатар хот**

### ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл:**Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтын "Засгийн газрын үндсэн бүтцэд ордог тусгай газар" гэснийг "Засгийн газрын агентлаг" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### ПАТЕНТИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Патентийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 5 дахь өгүүлбэрийн "Монгол Улсын Хууль зүйн сайд, Сангийн сайдын" гэснийг "патентийн асуудал эрхэлсэн сайд, санхүүгийн асуудал эрхэлсэн сайдын" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Патентийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд" гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### САДАР САМУУН ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 8.1.1, 9.1-ийн "гэгээрлийн" гэснийг "соёлын" гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### СОГТУУРАХ, МАНСУУРАХ ДОНТОЙ ӨВЧТЭЙ ЭТГЭЭДИЙГ ЗАХИРГААНЫ ЖУРМААР АЛБАДАН ЭМЧЛЭХ, АЛБАДАН ХӨДӨЛМӨР ХИЙЛГЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн 3.2-ын "эрүүл мэнд, нийгмийн хамгааллын" гэснийг "эрүүл мэндийн" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### СТАНДАРТЧИЛАЛ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 18 дугаар зүйлийн гарчиг болон 18.1-ийн "төрийн захиргааны төв байгууллага" гэснийг "Засгийн газрын гишүүн" гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр — Улаанбаатар хот

### ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР ХУДАЛДАН АВАХ БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийн 39.4, 39.6-ийн "дэд бүтцийн" гэснийг "барилга, хот байгуулалт, зам, тээвэр, түлш, эрчим хүчний" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД
ДАРГА — Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр — Улаанбаатар хот

### ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Орон сууцны тухай хуулийн 10.2-ын "төрийн захиргааны эрх бүхий" гэснийг "төрийн захиргааны төв" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД
ДАРГА — Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр — Улаанбаатар хот

### УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Усны тухай хуулийн 36.2-ыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"36.2. Энэ хуулийн 36.8-д зааснаас бусад улсын чанартай усны барилга байгууламж барих шийдвэрийг аймаг, нийслэлийн Засаг даргын санал болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэн барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана."

**2 дугаар зүйл.**Усны тухай хуулийн 14.1.3-ын "дэд бүтцийн" гэснийг "барилга, хот байгуулалтын" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД
ДАРГА — Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр — Улаанбаатар хот

### УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Усан замын тээврийн тухай хуулийн 8.2, 8.3, 14.1-ийн "төрийн захиргааны " гэсний дараа "төв" гэж тус тус нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД
ДАРГА — Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн гарчгийг "Шуудангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх" гэж, 6.1-ийн "Харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн" гэснийг "Шуудангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж, 6.2, 8.3-ын "харилцаа холбооны асуудал" гэснийг "шуудангийн асуудал" гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 4.1.3- 4.1.7 дахь заалт нэмсүгэй:

"4.1.3.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилга байгууламжийн захиалагчийн үүргийг Барилгын тухай[2] хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу гүйцэтгэх;

4.1.4.ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, өргөтгөх хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажил зохион байгуулах;

4.1.5.ус хангамж, ариутгах татуургын ашиглалттай холбогдуулан төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах;

4.1.6.орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

4.1.7.ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын норм, норматив боловсруулах;"

**2 дугаар зүйл.**Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дугаарыг "4.1.8" гэж, 13.1, 15.2, 15.3-ын "дэд бүтцийн" гэснийг "барилга, хот байгуулалтын" гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн "хүн амын бодлогын" гэснийг "хүүхэд, залуучуудын" гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### ШУДАРГА БУС ӨРСӨЛДӨӨНИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 12.5-ын "Хянан зохицуулах албаны даргын саналыг үндэслэн Сангийн сайд" гэснийг "улсын ерөнхий байцаагч " гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛУНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### ШҮҮДАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шүүдангийн тухай хуулийн 10.2.1-ийн "Зохицуулах хороо" гэснийг "шүүдангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛУНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийн 6.2.3-ын "дэд бүтэц" гэснийг "зам, тээвэр, аялал жуулчлал, барилга, хот байгуулалт, түлш, эрчим хүч" гэж, 6.5-ын "Ерөнхий сайдын дэргэдэх эдийн засгийн стратеги, төлөвлөлтийн алба" гэснийг "Шадар сайдын ажлын алба" гэж, 13 дугаар зүйлийн гарчгийн "төрийн захиргааны төв байгууллагын" гэснийг "Засгийн газрын гишүүний" гэж, 13.1-ийн "Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бүс нутгийн хөгжлийн асуудлыг хариуцаж" гэснийг "Бүс нутгийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛУНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, САНХҮҮЖИЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хуулийн 16.2.3-ын "Ерөнхий сайдын" гэснийг "Ерөнхий сайд, Шадар сайдын" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛУНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### КАДАСТРЫН ЗУРАГЛАЛ БА ГАЗРЫН КАДАСТРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд дор дурдсан агуулгатай 9[1] дүгээр зүйл нэмсүгэй:

**"9[1] дүгээр зүйл. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

9[1].1.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага кадастрын үйл ажиллагаатай холбоотой дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9[1].1.1.бүх ангиллын кадастрын зураглалын стандарт, технологийн аргачлал, дүрэм, журмыг батлуулан мөрдүүлэх;

9[1].1.2.геодези, зураг зүйн ажил эрхлэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд кадастрын зураглал хийх тусгай зөвшөөрөл олгох;

9[1].1.3.газрын кадастр хийх нутаг дэвсгэрийн ээлж дараалլыг тогтоох, газрын кадастрын судалгааг гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих."

**2 дугаар зүйл**. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 7.1-ийн "геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны" гэснийг "газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв" гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 7.5.1, 7.5.2, 10.2.3-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

### Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2004 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Женев хотноо гарын үсэг зурсан Олон улсын худалдааны мэдээлэл, хамтын ажиллагааны агентлагийг Засгийн газар хоорондын байгууллага болгон байгуулах тухай Хэлэлцээрийг батлалсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**

**ГАДААД ХЭРГИЙН САЙД Ц.МӨНХ-ОРГИЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

### Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн үлгэрчилсэн дүрмийг батлах тухай

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн үлгэрчилсэн дүрмийг хавсралт ёсоор батлалсугай.

2. Энэхүү дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид үүрэг болгосугай.

3. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн дүрмийг орон нутгийнхаа онцлогт тохируулан батлан мөрдүүлэх, цаашид үйл ажиллагааг нь тогтмолжуулахад анхаарч ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга нарт зөвлөсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ**

*Засгийн газрын 2005 оны 2 дугаар тогтоолын хавсралт*

**МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ САНГИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сан /цаашид "Сан" гэх/-г байгуулж, түүний үйл ажиллагааг явуулахад энэхүү үлгэрчилсэн дүрмийг удирдлага болгоно.

1.2. Сан нь мөнгөн хөрөнгийн сан байна.

1.3. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад хууль болон энэхүү үлгэрчилсэн дүрэмд нийцүүлэн тухайн орон нутгийн онцлогт тохируулан аймаг, нийслэл, сум, дүүргийн Сангийн дүрмийг холбогдох аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

1.4. Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл Санг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

Хоёр. Сангийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Сан нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл /цаашид "Зохицуулах салбар зөвлөл" гэх/-ийн дэргэд ажиллана.

2.2. Сангийн удирдах байгууллага нь Сангийн зөвлөл байна. Сангийн зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, орон тооны бус гишүүдээс бүрдэнэ. Гишүүдийн тоо 5-9 байна.

2.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга бөгөөд Зохицуулах салбар зөвлөлийн дарга нь Сангийн зөвлөлийн дарга байна.

2.4. Сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүдийг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас томилно.

2.5. Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг Сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга эрхлэн гүйцэтгэнэ.

2.6. Сангийн зөвлөл дараахь бүрэн эрхтэй байна:

2.6.1. Сангийн үйл ажиллагаа болон сангийн хөрөнгөөр санхүүжих арга хэмжээний жил, улирлын төлөвлөгөө, тэдгээрийн төсвийг хэлэлцэн батлах;

2.6.2. Сангийн хөрөнгөөр санхүүжих төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулах;

2.6.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах талаар гаргасан санал, санаачилгыг дэмжиж, хөдөлгөөн өрнүүлэх;

2.6.4. Сангийн хөрөнгөөр санхүүжиж байгаа арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн явц, үр дүнгийн тухай тайланг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгөх;

2.6.5. Сангийн зөвлөлийн дарга болон нарийн бичгийн дарга, гишүүдийн ажил, үүргийн хуваарийг батлах;

2.6.6. Сангийн улирал, жилийн ажлын тайланг хэлэлцэх.

2.7. Сангийн зөвлөлийн дарга нь Сангийн үйл ажиллагааг удирдан зохицуулж, сангийн хөрөнгийг энэ журмын 2.6.1-д заасны дагуу батлагдсан төлөвлөгөөнд заасан арга хэмжээнд зарцуулна.

2.8. Сангийн зөвлөлийн дарга нь Сангийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавьж, шаардлагатай гэж үзвэл санхүүжилтийг нь зогсоож, Сангийн зөвлөлийн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

2.9. Сангийн зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр нь оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.10. Сангийн зөвлөл асуудлыг тухайн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана. Сангийн зөвлөлийн тогтоолд дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

2.11. Сангийн зөвлөлийн хуралдааны явцын тухай тэмдэглэл хөтөлж, дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

2.12. Сангийн зөвлөл нь тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

2.13. Тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар Санг ажиллах нөхцөлөөр хангана.

2.14. Сангийн хөрөнгийг банкинд тусгай дансанд байршуулна.

Гурав. Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах

3.1. Сангийн хөрөнгө нь гадаад, дотоодын иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн тусламж, хандив болон хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

3.2. Сангийн хөрөнгийг дараахь үйл ажиллагаанд зарцуулна:

3.2.1. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг сурталчлах, тайлбарлан таниулах, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, арилгах;

3.2.2. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг гүйцэтгэж байгаа хүмүүсийг урамшуулах;

3.2.3. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагыг шагнах, урамшуулах.

3.3. Сангийн хөрөнгийг энэ дүрмийг 3.2-т зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

Дөрөв. Сангийн тайлан, бусад зүйл

4.1. Сангийн орлого, зарлагын тайлан мэдээг сум, дүүрэг бүр улирал бүрийн сүүлчийн сарын 25-ны дотор гаргаж, аймаг, нийслэлийн Зохицуулах салбар зөвлөлд; аймаг нийслэлийн Зохицуулах салбар зөвлөл улирал бүрийн дараа сарын 5-ны дотор Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд тус тус ирүүлнэ.

4.2. Сангийн бүрдүүлэлт, зарцуулалтад тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагаар жил бүр баримтын шалгалт хийлгэж байна.

4.3. Аймаг, нийслэлийн Сангийн зөвлөл нь Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд; сум, дүүргийн Сангийн зөвлөл нь аймгийн Зохицуулах зөвлөлд тус тус хагас, бүтэн жилээр үйл ажиллагаагаа тайлагнана. Тайлагнах журмыг Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дарга батална.

4.4. Сангийн зөвлөл нь үйл ажиллагааныхаа тайланг энэ дүрмийн 4.3-т заасан байгууллагад тайлагнахаас гадна тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон тухайн орон нутгийн иргэдэд жил бүр мэдээлнэ.

4.5. Гадаад, дотоодын иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс Санд оруулсан тусламж, хандивын хөрөнгийн зарцуулалтын тайланг шаардлагатай бол тухайн иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид хүргүүлж болно.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2005 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр** | **Дугаар 3** | **Улаанбаатар хот**

**Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтцийг батлах тухай**

Засгийн газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

-төрийн захиргааны төв байгууллагуудын хэлтэс;
-орон нутгийн байгууллагуудын хэлтэс;
-хуулийн хэлтэс;
-мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс;
-зохион байгуулалтын хэлтэс;
-боловсон хүчин, санхүүгийн алба;
-төрийн ёслолын алба;
-Засгийн газрын хэвлэл мэдээллийн алба;
-Ерөнхий сайдын ажлын алба;
-Шадар сайдын ажлын алба.

2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлагын орон тоог дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга тус бүр нэг байхаар тогтоосугай.

3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын орон тооны хязгаарыг 96-гаар тогтоосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл

ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус газрын бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1996 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 205 дугаар тогтоолын 2 дугаар зүйл, "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтцийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2000 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 145 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА С.БАЯРЦОГТ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2005 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр** **Дугаар 4** **Улаанбаатар хот**

**Тогтоолын хавсралт хүчингүй болгох тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2001 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 108 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ц.БАЯРСАЙХАН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2005 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр** **Дугаар 5** **Улаанбаатар хот**

**Хэлэлцээр батлах тухай**

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Пхеньян хотноо 2004 оны 12 дугаар сарын 21-ний өдөр гарын үсэг зурсан "Эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын Засгийн газар хоорондын зөвлөлдөх комисс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр"-ийг баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**

**ГАДААД ХЭРГИЙН САЙД Ц.МӨНХ-ОРГИЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2005 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр** **Дугаар 7** **Улаанбаатар хот**

**Төлбөрийн хувь хэмжээг тогтоох тухай**

Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ус ашигласан төлбөрийн хувь, хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төлбөрийн хувь хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 1995 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 154 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**

**САНГИЙН САЙД Н.АЛТАНХУЯГ**

**БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД У.БАРСБОЛД**

*Засгийн газрын 2005 оны 7 дугаар тогтоолын хавсралт*

## УС АШИГЛАСАН ТӨЛБӨРИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭ

| № | Ус ашиглалтын зориулалт | Хэмжих нэгж | Ус ашиглалтын төлбөр | |
|---|---|---|---|---|
| | | | Гадаргын ус | Газрын доорхи ус |
| 1 | Усан цахилгаан станц, усан замын тээвэр, усан спорт болон усны түгээмэл тархацтай амьтан, ургамал үржүүлэх зэрэг зориулалтаар ус ашигласны төлбөрийг тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний борлуулалтын орлогын дүнгээс | - | 1.0 хувь | - |
| 2 | Хүнд үйлдвэр | $м^3$/төг | 20.0 | 30.0 |
| 3 | Хөнгөн үйлдвэр | $м^3$/төг | 10.0 | 30.0 |
| 4 | Уул уурхайн үйлдвэр | $м^3$/төг | | |
| | -Алт, цагаан тугалга олборлолт | | 80 | 100 |
| | -Газрын тос олборлолт, цайр, хар тугалга баяжуулах | | 80 | 100 |
| | -Зэсийн баяжмал, хайлуур жонш баяжуулах | | 80 | 100 |
| 5 | Хүнсний үйлдвэр | $м^3$/төг | | |
| | -ундаа | | 10.0 | 30.0 |
| | -бусад | | 10.0 | 30.0 |
| 6 | Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн | $м^3$/төг | | |
| | 1/Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот | | 10.0 | 30.0 |
| | 2/Баян-Өлгий, Ховд, Увс, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв, Завхан, Архангай, Өвөрхангай, Дорнод, Хэнтий аймгийн төв, бусад хот, суурин газар | | 10.0 | 10.0 |
| | 3/Баянхонгор,Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Говь-Алтай, Өмнөговь аймгийн төв, бусад хот, суурин газар | | 10.0 | 30.0 |

*Тайлбар: 1. Эрчим хүчний болон мал, амьтан, газар тариалангийн үйлдвэрлэл, хүн амын унд, ахуйн хэрэглээнд ашигласан усыг төлбөрөөс чөлөөлнө.*

*2.Хавсралтын 6-д заасан аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй ус ашигласны төлбөрийг ус түгээгч тооцон авна.*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2005 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр** | Дугаар 9 | **Улаанбаатар хот**

**Гадаадаас 2005 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай**

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад 2005 онд хөдөлмөр эрхлүүлэхээр гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг хавсралт ёсоор батлагсугай.

2. Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр байгуулах, тендер зарлах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд энэ тогтоолын хавсралтад заасан хувийг баримталж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

3. Гадаад хэл дагнасан боловсрол, шинжлэх ухааны байгууллагад хөдөлмөр эрхлэх гадаадын ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг нийт ажиллагчдын 70 хүртэл хувь, монголын боловсролын байгууллагад ажиллах гадаадын ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг нийт ажиллагчдын 30 хүртэл хувь байхаар тус тус тогтоосугай.

4. Хавсралтад заагдаагүй салбарт гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тухайн байгууллагын нийт ажиллагчдын 5 хүртэл хувиар тогтоосугай.

5. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, улсын хэмжээний зам, барилга байгууламж барихад гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтэнтэй холбоотой асуудлыг энэ тогтоолын дагуу шийдвэрлэх боломжгүй бол тухай бүрт Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлж байхыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайханд даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Гадаадаас 2004 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай" Засгийн газрын 2003 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 268 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ц.БАЯРСАЙХАН**

*Засгийн газрын 2005 оны 9 дүгээр тогтоолын хавсралт*

## МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИД 2005 ОНД ХӨДӨЛМӨР ЭРХЛҮҮЛЭХЭЭР ГАДААДААС АВАХ АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТНИЙ ЭЗЛЭХ ХУВЬ

| Салбар, дэд салбар | Бүлэг, дэд бүлэг | Хөрөнгө оруулалт /дүрмийн сангийн хэмжээ, сая төгрөг/ | 50 хүртэл | | | 50-100 | | | 100-500 | | | 500 ба дээш | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт Ажиллагчдын тоо | 100 хүртэл | 101-500 | 501-ээс дээш | 100 хүртэл | 101-500 | 501-ээс дээш | 100 хүртэл | 101-500 | 501-ээс дээш | 100 хүртэл | 101-500 | 501-ээс дээш |
| AO1 | | **ХӨДӨӨ АЖ АХУЙ** | | | | | | | | | | | | |
| | 11 | Газар тариалан | 8 | 9 | 10 | 9 | 10 | 11 | 10 | 11 | 12 | 11 | 12 | 13 |
| | 12 | Эрчимжсэн мал аж ахуй | 6 | 7 | 8 | 8 | 9 | 10 | 9 | 10 | 11 | 10 | 11 | 12 |
| C | | **УУЛ УУРХАЙ,ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛ** | | | | | | | | | | | | |
| C10 | | Нүүрс олборлолт | 6 | 7 | 8 | 8 | 9 | 10 | 9 | 10 | 11 | 10 | 11 | 12 |
| C11 | | Газрын тос, шатдаг хийн хайгуул | 70 | 80 | 90 | 90 | 90 | 90 | 90 | 90 | 90 | 90 | 90 | 90 |
| C13 | 1320 | Алт болон бусад үнэт металлын эрэл хайгуул, олборлолт | 23 | 28 | 33 | 28 | 33 | 38 | 33 | 38 | 43 | 34 | 39 | 44 |
| C13 | 1310 | Төмрийн хүдэр олборлолт | 8 | 9 | 10 | 9 | 10 | 11 | 10 | 11 | 12 | 11 | 12 | 13 |
| C14 | 1410 | Чулуу, элс, шороо, давс, химийн болон бордооны, ургамлын олборлолт | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 | 9 | 10 | 11 |
| D | | **БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ** | | | | | | | | | | | | |
| D15 | 151-153 | Хүнсний бүтээгдэхүүн,ундаа үйлдвэрлэл | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| D17,18,19 | | Нэхмэл,оёдол,арьс шир боловсруулалт,бүтээгдэхүүн үйлдвэрлэлт | 8 | 9 | 10 | 9 | 10 | 11 | 10 | 11 | 12 | 11 | 12 | 13 |
| D20, 21 | 201,202, 210 | Мод,модон эдлэл,цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 | 9 | 10 | 12 |
| D23 | 2310, 2320, 2330 | Кокс,шингэн болон цацраг идэвхт түлш үйлдвэрлэл | 4 | 5 | 6 | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 |
| D24 | | Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 10 | 12 | 10 | 15 | 20 |
| D25 | 2510, 2520 | Резин,хуванцар, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 9 | 10 | 12 |
| D27, 28 | | Төмрийн үйлдвэрлэл,төмөр эдлэл үйлдвэрлэл | 8 | 9 | 10 | 9 | 10 | 11 | 10 | 11 | 12 | 11 | 12 | 13 |
| D | 369 | Боловсруулах аж үйлдвэрийн бусад бүтээгдэхүүн | 8 | 9 | 10 | 9 | 10 | 11 | 10 | 11 | 12 | 11 | 12 | 13 |
| D | 29 | Машин, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| E40 | | Цахилгаан хий үйлдвэрлэл,ус хангамж | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| D | 269, 4520 | Барилгын материалын үйлдвэрлэл, барилга угсралт | 10 | 15 | 20 | 15 | 20 | 25 | 20 | 25 | 30 | 25 | 30 | 35 |
| F | | АВТО ЗАМ БАРИЛГА | 15 | 20 | 25 | 20 | 25 | 30 | 25 | 30 | 35 | 30 | 32 | 35 |
| G50 | | **БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА** | 12 | 14 | 16 | 14 | 16 | 18 | 16 | 18 | 20 | 18 | 20 | 22 |
| H55 | 5510 | **ЗОЧИД БУУДАЛ,ЗООГИЙН ГАЗАР** | 10 | 15 | 20 | 15 | 20 | 25 | 20 | 25 | 30 | 25 | 30 | 35 |
| G50 | 5020, 5040, 5260 | Автомашин,мотоцикл,гэр ахуйн барааны засвар, үйлчилгээ | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| H60 | | **ТЭЭВЭР ХОЛБОО, АГУУЛАХЫН АЖ АХУЙ** | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| H | | АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ | 10 | 15 | 20 | 15 | 20 | 25 | 20 | 25 | 30 | 25 | 30 | 35 |
| O | | НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ,ХҮН АМ, НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| | | БУСАД | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 |

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**"Төрийн Мэдээлэл"** эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12,
Төрийн ордон
☎ 329612
Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 2.5